Агуулга

**Илтгэлийн сэдэв:** Барилгын мэргэжлийн дагуу түншлэгч байгууллагуудын хүрээг тэлсэнээр үйлдвэрлэлийн дадлагын чанар, дадлагажигчийн ур чадварт сайнаар нөлөөлөх нь

**Илтгэлийн түлхүүр үгс:** Дадлага, түншлэгч байгууллага, багш, дадлагажуулагч, дадлагажигч


**Оршил**

- Зорилго
- Зорилт

**Онолын хэсэг**

- Манай сургууль, бусад байгууллага хоорондын түншлэл, хамтын ажиллагаа ба үйлдвэрлэлийн дадлагын чанарт хэрхэн нөлөөлж буй байдал
- Техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалтын салбарт бий болоод байгаа ололт, амжилтууд
- Түншлэгч байгууллагуудын хүрээг тэлэх, харилцан хамтын ажиллагааг хэрхэн сайжруулах тухайд
- Үйлдвэрлэлийн дадлагаар чадварлаг оюутан бэлтгэхийн тулд цаашид сургалтын байгууллага, мэргэжлийн багш нарынхаа ур чадварт анхаарах нь

**Практик хэсэг / судалгаа /**

- Судалгааны зорилго
- Судалгааны арга зүй
- Судалгааны асуулга
- Судалгаанаас гарсан үр дүн

**Дүгнэлт**

***Ном зүй***

**Хавсралт**

## Барилгын мэргэжлийн дагуу түншлэгч байгууллагуудын хүрээг тэлсэнээр үйлдвэрлэлийн дадлагын чанар, дадлагажигчийн ур чадварт сайнаар нөлөөлөх нь

**Зорилго:** Үйлдвэрлэлийн дадлагыг мэргэжлийн байгууллага дээр нь албан ёсны гэрээтэйгээр хийлгэж, дадлагажигч оюутны мэргэжлийн ур чадварын ахицад анхаарах

**Зорилт:**

- Түншлэгч байгууллагуудын хүрээг тэлэх, харилцан хамтын ажиллагааны гэрээнд дадлагажигчийг чадваржуулах хөшүүрэг оруулах
- Үйлдвэрлэлийн дадлагаар чадварлаг оюутан бэлтгэхийн тулд цаашид сургалтын байгууллага, мэргэжлийн багш нарынхаа ур чадварт анхаарах нь
- Манай сургуулиас бэлтгэн гаргадаг Барилгын цахилгаан монтаж, Барилгын засал чимэглэл гэсэн хоёр мэргэжлийн ангийн дадлагажуулагч, дадлагажигчийн харилцан хамаарал, дадлага ажлын уялдаа холбоог мэдэхийн тулд асуулгын аргаар судлагаа авч дүгнэлт гаргах

## Манай сургууль, бусад байгууллага хоорондын түншлэл, хамтын ажиллагаа ба үйлдвэрлэлийн дадлагын чанарт хэрхэн нөлөөлж буй байдал

Мэргэжлийн боловсрол, сургалтын салбарын шинэчлэл нь хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцүүлэх, төр, хувийн хэвшлийн түншлэлийн бодит механизм бүрдүүлж төлөвшүүлэх, үйлдвэрлэлийн хөгжлийн хэрэгцээтэй холбож төрөлжүүлэх, сургалтын стандарт, хөтөлбөрийг шинэчлэх, багш нарыг заах арга зүй болон мэргэшсэн инженер техникийн ажилтны түвшинд хүргэж чадваржуулах, үйлдвэрлэл-дадлагын сургалтын бааз, лабораторийг орчин үеийн шаардлагад нийцүүлэх, сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүнээр хангах, иргэдийн хэрэгцээнд суурилсан үйлчилгээг нэвтрүүлэх, эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх асуудлыг хамарч байна хэмээн хөгжлийн хөтөлбөрт тусгасан байна.

Иймд МБС-ын салбар нь барилга, уул уурхай, хүнс хөдөө аж ахуй, аж үйлдвэр, зам тээвэр, үйлчилгээ зэрэг тэргүүлэх салбарт мэргэжилтэй ажилтны эрэлтийг хангаж, хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжин, ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, эдийн засаг, нийгмийн тогтвортой хөгжлийг хангахад чухал түлхэц өгдөг салбар юм.[1]

Манай сургуулиас бэлтгэн гаргадаг Барилгын цахилгаан монтаж, Барилгын засал чимэглэлийн энэ хоёр мэргэжлийн ангийн хувьд төгчсөгчдийн дийлэнх нь хөдөлмөрийн зах зээл дээр, ажлын байрны олдоц хангалттай сайн байдаг хэдий ч дээрх мэргэжлээр бэлтгэгдэн гарч байгаа суралцагчид маань бодит байдал дээр дийлэнх нь буюу 75 – 85% мэргэжлийнхээ дагуу ажил, хөдөлмөр эрхэлж хараахан чадахгүй байгаа нь учир дутагдалтай байна.

Мэргэжлийн боловсролын хөгжлийн 2016 – 2021 оны хөтөлбөрт энэ тухай хэрхэн тусгасан байдаг тухайд

А. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцүүлэх

Б.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн бодит механизм бүрдүүлэх [2]

МБСБ – аас гаргасан энэхүү бодлого шийдвэрийг бодит байдал дээр хангалттай сайн хэрэгжүүлж чадахгүй байгаа билээ. Учир нь Говьсүмбэр Политехник Коллежийн түншлэн ажиллаж буй аж ахуйн нэгж, байгууллагуудыг доор жагсаавал:

А. Beiben truck
Б. "Шивээ овоо" ХХК
В. "Мак цемент" ХХК
Г. "Гексаэдр клауд" ХХК
Д. "Говь Урал"
Е. "УСДУ"
Ё. "Замын III анги"
Ж. Орон сууц

Дээрх байгууллагуудын ихэнх нь уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг бол ганцхан "Гексаэдр клауд" ХХК барилга угсралтын компани бөгөөд манай байгууллага түншлэлийн гэрээ байгуулаад удаагүй учраас тухайн компани дээр дадлага хийсэн оюутан, суралцагч одоогоор байхгүй.

---

[1] Мэргэжлийн болон техникийн боловсролыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр 2016 - 2021

[2] Мэргэжлийн болон техникийн боловсролыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр 2016 - 2021

Иймд барилгын ангийн суралцагчдад үйлдвэрлэлийн дадлагаа хийх түншлэгч байгууллага хангалттай байхгүй байгаа нь хамгийн нэн тэргүүнд үйлдвэрлэлийн дадлага чанаргүй болох, цаашлаад дадлагажигчийн мэргэжлийнхээ дагуу мэдлэг, ур чадвараа ахиулах боломжийг хаалттай болгож байгаа юм.

Хэдийгээр үйлдвэрлэлийн дадлагаа тухайн оюутан, суралцагч өөрөө, хувиараа аль нэг аж ахуйн нэгж, байгууллага юмуу хувийн компани дээр олж хийх тохиолдол давамгай байгаа боловч олон талаар ач холбогдол багатай нь бодит байдал дээр ажиглагдаж байдаг. Асуумж судалгааны үндсэн дээр эдгээрээс дурьдхад:

А.Мэргэжлийн хамааралгүй аж ахуйн нэгж, байгууллага дээр дадлагаа хийх

Б.Мэргэжлийн бус хүнээр үйлдвэрлэлийн дадлагаа удирдуулах

В.Дадлага ажлын удирдамжинд заагдсан гол гол ажлыг хийж гүйцэтгэж үзэлгүй, дадлагын хугацааг дуусгах

Г.Тухайн дадлагажигчийг хариуцсан хүн мэргэжлийн мэдлэг, ур чадварыг нь ахиулах тал дээр анхаарч ажиллахгүй байх

Д.Дадлага ажлын хугацааг тогтоосон хугацаанаас цөөн хоногоор хийж, дадлага ажлын ач холбогдолыг сулруулах зэрэг дутагдалтай тал олон байна.

Үйлдвэрлэлийн дадлагаа чанаргүй, мэргэжлийн бус байгууллага дээр хийсэн оюутан, суралцагчид цаашид мэргэжлээрээ ажиллах дур сонирхолгүй болохоос гадна зарим талаар төгсөгч маань ажлын байран дээр гарлаа гэхэд ажил олгогчид гологдож байгаа нь бодит үнэн юм.

Техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалтын салбарт бий болоод байгаа ололт, амжилтууд

1.МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫН САЛБАРТ ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ТААТАЙ ОРЧИН БҮРДЭЖ БАЙНА. Техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалтын харилцааг 2002 он хүртэл “Боловсролын тухай” болон “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай” хуулийн хүрээнд зохицуулж ирсэн. УИХ 2002 онд “Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай” анхны бие даасан хуулийг батлан гаргаснаар техник, мэргэжлийн боловсрол, сургалтыг хөдөлмөрийн зах зээлд нийцүүлэх асуудалд анхаарал хандуулах болсон.

2. МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫГ ЧАДАМЖИД СУУРИЛСАН СУРГАЛТАД ШИЛЖҮҮЛЭН ХӨГЖҮҮЛЖ БАЙНА. МБС-ын салбарыг системээр нь өөрчлөн хөгжүүлэх, олон улсын түвшинд хүргэхэд ЧСС-ын тогтолцоог бүрдүүлэх асуудал тэргүүнд тавигдаж, олон улсын туршлагыг нэвтрүүлэх асуудлын хүрээнд томоохон донор байгууллагууд хамтран ажиллаж байна. Шинэчлэлийг эхлүүлэхэд АНУ-ын Мянганы сорилтын сангийн компакт гэрээний дагуу 2008-2012 онд төсөл хэрэгжиж үнэтэй хувь нэмэр оруулсан. [3]

3. НИЙГМИЙН ТҮНШЛЭЛ, ХАМТЫН АЖИЛЛАГАА САЙЖИРЧ БАЙНА. Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 2009 онд хийсэн шинэчилсэн найруулгаар Мэргэжлийн боловсрол, сургалтын талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэхэд төр, хувийн хэвшлийн тэнцүү оролцоог хангасан Үндэсний зөвлөл байгуулж, тус зөвлөл нь МБС-ын дээд удирдлагыг хэрэгжүүлнэ гэж хуульчилсан.

---

[3]Мэргэжлийн болон техникийн боловсролыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр 2016 - 2021

4.МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ТОГТОЛЦООНЫ ШИНЭЧЛЭЛ МБС-ын асуудал 2012 онд Хөдөлмөрийн яаманд харьяалагдах болсон.

2016 оны МБС-ын тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөөр "Мэргэжлийн боловсрол, сургалтын тогтолцоо нь үндэсний зөвлөл, мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, үнэлгээ, мэдээллийн болон бүсийн арга зүйн төв, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагаас бүрдэхээр заасан.

5.ТӨГСӨГЧДИЙН УР ЧАДВАР САЙЖИРЧ, ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ НЭМЭГДЭЖ БАЙНА Сүүлийн жилүүдэд Мэргэжлийн боловсрол, сургалтын нэр хүнд өсч, элсэгчдийн тоо нэмэгдсэнээс гадна төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт жилээс жилд өсч байна. Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн 2015 оны үзүүлэлтийг 2009 онтой харьцуулахад 62,4% болж 20,9%-аар нэмэгдсэн.[4]

Үндэсний мэргэжилтэй ажилтан бэлтгэх хөтөлбөр (2012-2014): Ажил олгогчдын захиалгад тулгуурлан мэргэжилтэй ажилтныг бэлтгэж шууд ажлын байртай холбосон онцлогтой хөтөлбөр хэрэгжсэн. Үүний үр дүнд 150 орчим аж ахуйн нэгж байгууллага 4126 ажлын байрны захиалгыг өгч нийт 8417 иргэн хөтөлбөрт хамрагдсанаас 7137 иргэн шууд ажлын байраар хангагдсан байна.

- "Дэлхийн ур чадвар"–ын тэмцээнд амжилттай оролцсон: Монгол Улс 2014 онд Дэлхийн ур чадварын олон улсын байгууллагад гишүүнээр элсэн 2015 "Дэлхийн ур чадвар"-ын тэмцээнд багаа бэлтгэн 43 дахь удаагийн олон улсын тэмцээнд амжилттай оролцсон.

1. МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫН ОРЧИН САЙЖИРЧ БАЙНА. МБС-ын байгууллагуудын сургалтын орчныг сайжруулахад 2010 оноос хойш 7 донор байгууллагуудын төсөл хэрэгжиж, нийт 44 сая ам.долларын хөрөнгө оруулалтыг сургалтын орчинг сайжруулахад зориулан 7 шинэ болон өргөтгөлийн барилга барих, 12 МБСБ-ын хичээл, дадлагын байрыг засварлах, давхардсан тоогоор 38 мэргэжлийн шинэ дэвшилтэт тоног төхөөрөмж нийлүүлэх ажлыг гүйцэтгэсэн байна. [5]

---

[4] "Ажилтай, орлоготой монгол хүн" Үндэсний хөтөлбөр

[5] Хөдөлмөрийн яамны Мэргэжлийн боловсрол, сургалтын бодлого зохицуулалтын газар, Мэргэжлийн боловсрол, сургалтын статистик мэдээлэл, 2015-2016 оны хичээлийн 1 хагас жил, 2016 он

## Түншлэгч байгууллагуудын хүрээг тэлэх, харилцан хамтын ажиллагааг хэрхэн сайжруулах тухайд

Чадамжид суурилсан сургалтын гол зарчим нь мэргэжлийн ур чадварыг академик онолоос илүүтэй дадлага ажил, практик сургалтанд суурилан орчин үеийн технологид нийцсэн дадлагын орчинд тоног төхөөрөмж багаж, хэрэгсэлд гараар хүрч ажиллан бодитоор мэдрэн сурах замаар олгоход чиглэдэг тул төгсөгч бэлтгэн гаргадаг мэргэжлийнхээ дагуу түншлэгч байгууллагуудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлэхэд анхааран ажиллах нь бидний хамгийн ойрын зорилт байх ёстой гэж үзэж байна.

Сургууль дээр явагдаж байгаа дадлага ажлын цаг ч гэсэн онолын мэдлэгийг 20 хувь, дадлага ажлаас олж авах мэдлэгийг 80 хувьд хүргэхэд анхаарч сургалтаа явуулах нь чухал байгаа юм.

Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөөр 50-иас дээш ажилтантай аж ахуйн нэгж суралцагчийн үйлдвэрлэлийн дадлагын ажлыг зохион байгуулж, удирдан чиглүүлэх үүрэг бүхий дадлагажуулагч багш ажиллуулна гэж заасан байдаг байна.

Энэхүү хуулийн заалтын хэрэгжилт бодит байдал дээр хэрэгжихгүй байгаа боловч дадлагын сургалтын чанарыг сайжруулахад анхааран ажиллах ажлын хүрээнд аж ахуйн нэгж байгууллагад, сургууль хамтран ажиллах санал тавин, түншлэлийн гэрээ байгуулан ажиллах нь чухал билээ.

Аливаа нэгэн томоохон нэр хүнд бүхий байгууллагатай түншлэлийн гэрээ байгуулахын өмнө тухайн байгууллагаас дадлагажигч оюутан, суралцагчаас ямар харилцаа, хандлагатай, өөрийн сурдаг мэргэжлийн түвшинд ямар мэдлэг, ур чадвартай байх шалгуур тавьж байгааг албан бичгээр дамжуулан авч, улмаар тэрхүү шалгуурт тэнцсэн дадлагажигчийг тухайн байгууллагад түншлэлийн гэрээний дагуу үйлдвэрлэлийн дадлага хийлгэж байх нь хамтын ажиллагааны гэрээгээр хүлээсэн үүрэгт болоод түншлэгч хоёр байгууллагын харилцан итгэлцэл, цаашдын хамтын ажиллагаанд сэв суухгүй байх зэрэг давуу тал олон байгаа юм.

Түншлэгч байгууллага уруу гэрээгээр дадлага хийх оюутан, суралцагчид сургууль дотоод журмаар зохицуулалт хийн, тодорхой шалгуур тавьж, цэнзүүртэйгээр буюу шалгарсан оюутан, суралцагч байвал тухайн байгууллага дээр очоод харилцаа хандлага болоод хариуцлага сайтай, тодорхой мэргэжлийнхээ түвшинд онолын болоод ур чадварын түвшингээр гологдохооргүй байдлыг харгалзан үзэж гэрээ байгуулсаны үндсэн дээр дадлагад гаргах нь цааш цаашдын хамтын ажиллагааг тасралтгүй үргэлжлүүлэх, өргөжүүлэхэд чухал алхам болно гэж үзэж байна.

Мэргэжлийн багшийн зүгээс ч гэсэн "Түншлэгч байгууллага" – руу дадлага хийхээр явах хүсэлтэй байгаа оюутан, суралцагчаас тусгайлан боловсруулсан чадамжийн нэгжийн гүйцэтгэлээр шалгалт аваад, тэнцсэн тохиолдолд, сургалтын албаны албан ёсны зөвшөөрөлтэйгөөр дадлагад гарах эрхийг олгож байх нь эргээд тухайн оюутан, суралцагч маш том үүрэг, хариуцлагыг давхар өөртөө ухамсарлах нь дамжиггүй.

Илтгэлийнхээ судалгааны ажлаар хэд хэдэн хүнтэй холбогдож, сургуулийнхаа сургалтын чиглэл, үйл ажиллагааны чиглэлийг танилцуулсаны үр дүнд нэр бүхий дөрвөн компанитай хамтран ажиллах хүсэлтээ тавиад 3 компани нь, хамтран ажиллах гэрээ байгуулахыг зөвшөөрч, "Алтайн хүдэр" ХХК – ийн цахилгааны инженер Ж.Тулга албаны хүнтэйгээ холбоо бариад, эргээд хариу өгөхөө мэдэгдсэн юм.

### Үйлдвэрлэлийн дадлагаар чадварлаг оюутан бэлтгэхийн тулд цаашид сургалтын байгууллага, мэргэжлийн багш нарынхаа ур чадварт анхаарах нь

- Бүх салбарт багшид тавьж буй мэдлэг, ур чадвар, заах арга зүйн шаардлага шинэчлэгдэж байна. Манай мэргэжлийн боловсрол сургалтын багш л гэхэд аж ахуйн нэгж дэх инженер техникийн ажилтантай дүйхүйц, түүнээс илүү түвшний мэдлэг, мэргэшлийн ур чадвартай, бизнес сэтгэлгээтэй, сургах зүйн идэвхитэй, бүтээлч аргуудыг эзэмшсэн, өндөр ёс зүйтэй байх шаардлагад нийцэх хэрэгтэй байна.[6]

Яг өнөөгийн нөхцөлд манай багш нарын мэдлэг, ур чадвар, туршлага өнөөгийн шаардлагаас хоцронгуй, үйлдвэр аж ахуйн газарт мэргэшил дээшлүүлэх боломж хязгаарлагдмал байгаа нь багшийн чадвар, сургалтын чанарт сөргөөр нөлөөлж байгааг хүлээн зөвшөөрөхөөс аргагүй.

Иймд зөвхөн оюутан, суралцагчийг дадлагажуулж, чадваржуулах тухай яриад байх нь өрөөсгөл ойлголт юм. Тухайн мэргэжлийн багшаа сургалтын байгууллагын зүгээс мэргэшлийн чиглэл таарсан, тухайн салбарт шинэ дэвшилтэт техник, технологиор үйл ажиллагаа, үйлчилгээ явуулдаг аж ахуйн нэгж, байгууллага, компанитай хамтран ажиллаж үр дүнд хүрч болох юм. Жишээ нь:

- Туршлага судлуулах
- Багш солилцооны нэг сарын хөтөлбөр хэрэгжүүлэх
- Цахилгаан станц дээрх техник, тоног төхөөрөмжтэй танилцуулах
- Барилга угсралтын компаны шинэ дэвшилтэт арга туршлагатай танилцуулах
- Барилгын дотоод засал чимэглэлийн шинэ дэвшилтэт техник технологи, багж тоног төхөөрөмж дээр ажиллах туршлага хуримтлуулах
- Үйлдвэр, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаатай танилцах
- Барилгын мэргэжлийн багшийг барилгын дотоод засал чимэглэл хийж байгаа барилгын компани дээр ур чадварын түвшин ахиулах дадлага хийлгүүлэх
- Үйлдвэр, аж ахуйн нэгж, томоохон уурхай, хувийн компаны үйл ажиллагаатай танилцуулах хөтөлбөр хэрэгжүүлэх
- Цахилгааны холболт, угсралтын компанид очиж, туршлага судлах гэх зэргээр мэргэжлийн багшаа ажил мэргэжлийн талбар дээр хөгжих, мэргэжлийн дагуу ур чадвараа ахиулах тал дээр санаачлага гарган, дэмжин ажиллах нь чухал билээ.

Хөгжсөн багшаас, хөгжсөн суралцагч төрөн гарах нь дамжиггүй юм. 2020 онд манай байгууллага шинээр хамтран ажиллах гэрээ байгуулсан "Гексаэдр клауд" ХХК нь цахилгааны холболт, угсралтын үйл ажиллагаа эрхэлдэг ба түншлэлийн гэрээнийхээ дагуу очиж, мэргэжлийн багш нь дадлагажигч оюутан, суралцагчийг ямар, хөтөлбөрийн дагуу сургаж, бэлтгэдэг болон үйлдвэрлэлийн дадлагад гарахын өмнө тухайн оюутан, суралцагчид багшийн зүгээс ямар ямар мэргэжлийн мэдлэг, ур чадварыг эзэмшүүлдэг тухайгаа танилцуулаад, цаашид тухайн компани дээрх үйлдвэрлэлийн дадлагаар хэрхэн чадваржуулах хүсэлтэй байгаагаа танилцуулах зэргээр харилцан зөвшилцөлд хүрэх зэргээр уялдаатай ажиллаж чадвал дадлагажигч оюутан, суралцагчийн үйлдвэрлэлийн дадлагаас олж авах мэдлэг, ур чадварт маш их ахиц гаргана гэж найдаж байна.

---

[6] ХНХЯ-ны Мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагын багш нарын анхдугаар зөвлөгөөн

## СУДАЛГААНЫ АЖИЛ

### Судалгааны зорилго

ГСА-ПТК-ийн сургуулиас бэлтгэн гаргадаг барилгын цахилгаан монтаж,барилгын засал чимэглэл гэсэн хоёр мэргэжлийн ангийн үйлдвэрлэлийн дадлагын чанарыг ахиулахын тулд дадлагажуулагч,дадлагажигчийн уялдаа холбоог хойшид сайжруулахад юунд анхааран ажиллах талаар асуулгын аргаар судлагаа авч, дүн шинжилгээ хийхэд оршино.

### Судалгааны арга зүй

Энэхүү судалгаандаа бид, аж ахуйн нэгж, оюутнууд гэсэн хоёр субьектийг сонгож, нийт 12 аж ахуйн нэгжийн албан тушаалтан, 21 суралцагчийг судалгаанд хамруулж, нээлттэй асуулгын хэлбэрээр "Google docs" программыг ашиглан түүврийн аргаар судалгаа явуулсан.

Мөн томоохон уул уурхайн компанийн цахилгааны инженерүүдтэй утсаар холбогдон илтгэлийн сэдвийн хүрээнд гол гол зүйлсийг асууж тодруулсан. Ажлын байран дээрээ гаргасан холбогдох "Мөшгих судалгаа" болон оюутан, суралцагчдын үйлдвэрлэлийн тайлан хамгаалах үйл явц, тэдний ур чадварын өсөлт, ололт амжилт дээр байнга практик ажиглалтыг хийж байсан зэрэг туршлага дээрээ үндэслэн энэхүү сэдвийг хөндөн бичсэн ба судалгааны асуулгаа боловсруулж, сэдвийн гол санаа, дүгнэлтээ гаргахад хуримтлуулсан туршлага маань чухал нөлөөтэй байлаа.

### Судалгаанаас гарсан үр дүн

- Тухайн суралцагчийн дадлагын удирдамжинд заагдсан, хийж гүйцэтгэх ажлуудыг бүрэн гүйцэд хийлгэж чадаагүй гэж 75% нь хариулсан.
- Дадлагажуулагч, дадлага хийлгэх явцдаа дадлагажигчийн суурь чадварыг дунд зэрэг байсан гэж 50% үнэлсэн байна.
- Говьсүмбэр аймаг дахь Политехник коллежтэй албан ёсны гэрээтэй түншлэгч байгууллага мөн гэж - 17% хариулсан.
- Дадлагажигчаар очсон суралцагчийн, мэргэжлийн суурь чадвар сул тааруу, хангалтгүй байсан гэж судалгаанд оролцогчид – 100% бөглөсөн байна.
- Дадлагажигч оюутан, суралцагчидыг, таны олгосон мэргэжлийн мэдлэг, чадварын ахицын түвшин нь хэр болсон гэсэн асуумжинд маш сайн гэж хариулсан хүн байхгүй, сайн - 58, дунд зэрэг – 33%, бага зэрэг гэж - 8% нь хариулсан байна.

Илтгэлийнхээ судалгааны ажлаар хэд хэдэн хүнтэй холбогдож, сургуулийнхаа сургалтын чиглэл, үйл ажиллагааны чиглэлийг танилцуулсаны үр дүнд мэргэжлийн багш нар болон оюутан, суралцагч нараасаа дадлагажуулах хүсэлтэй байгаагаа уламжилсаны үр дүнд дараах хувийн хэвшлийн компаниуд хамтран ажиллах хүсэлтийг маань хүлээн авсан таатай мэдээг дуулгахад сайхан байна.

"Шивээ – Овоо" ХК – тай манай сургууль албан ёсны гэрээтэй ажилладаг ба ихэнхдээ ХММ – ын ангийн оюутан, суралцагчид танилцах дадлага болон үйлдвэрлэлийн дадлагаа очиж хийдэг.

Тус уурхайн ерөнхий инженер Д. Батмөрөнтэй 99992590 утсаар холбогдон БЦМ, БЗЧ гэсэн хоёр ангийн хүрээнд дадлага хийх боломж, нөхцөл ямар байгааг асууж тодруулсан юм.

2,5 жилийн дээрх ангиудаас илүү УУЭТТ – ийн техникч 3 жилийн ангийн оюутнууд болон барилгын цахилгааны мэргэжлийн багш нар маань үйлдвэрлэлийн орчин, суурин тоног төхөөрөмж, дэвшилтэт техник технологитой танилцах боломж нөхцөл байгааг олж мэдлээ.



Говьсүмбэр аймгийн маань Нэгдсэн эмнэлэгийн шинэ барилгын ажил дээр ажилласан “Материал трейд” ХХК барилга, угсралт, үйлдвэрлэлт, угсралтын үйл ажиллагаа явуулдаг компани юм байна. Энэ компани дээр БЦМ – 3А ангийн 5 суралцагч үйлдвэрлэлийн дадлагаа хийснийг судалгаа авахдаа мэдсэн.

Улмаар тус компанийн цахилгааны инженер Э.Батцэрэнтэй 99252047 утсаар холбогдон хойшид оюутан, суралцагчаа дадлагажуулах чиглэлээр хамтран ажиллах хүсэлт тавихад зөвшөөрсөн юм.



Барилга, угсралтын “MAXIZ” компанийн гүйцэтгэх захирал Шижир – Отгонтой утсаар холбогдож, хүсэлт тавихад таатай хүлээн авч, хамтран ажиллах гэрээ байгуулахаар болсон юм.



"Хэт хүч" ХХК – ийн үйлдвэр хариуцсан борлуулалтын менежер М. Гантулгатай 96793269 утсаар холбогдон сургуулийнхаа оюутан, суралцагчийг дадлагажуулах хүсэлтэй байгааг хэлэхэд таатай хүлээн авсан юм. Тус компани нь даацын хавтан, даацын налуу зэрэг барилга угсралтын том хэмжээний бэлдэцүүдийг үйлдвэрлэн гаргадаг.

Манай зам, барилгын машины операторын ангийн оюутнууд дадлагаа хийх болон цаашид ажлын байраар хангагдах бүрэн боломжтой ба цаашид гүүрэн кран, оосорлогч кран, тоног төхөөрөмжийн оператор гэсэн мэргэжлийн ангитай болвол хамтран ажиллах хүрээ тэлэх боломжтой юм байна.




Хэт Хүч ХХК

Бидний тухай

Хэт хүч" ХХКомпани нь Монгол улсын стандартын дагуу 2003 оноос барилгын

- ХӨНДИЙТЭЙ НҮХТЭЙ ХАВТАН
- ЗООРИЙН ХАНЫН ГУЛДМАЙ
- ТӨМӨР БЕТОН ШОН
- ДААЦЫН, ДААЦЫН БУС ЯЛУУ

Хэт Хүч ХХК

ШУТИС-иин Барилга Архитектурын сургуулийн оюутнууд үйлдвэртэй танилцах дадлага хийлээ.
Эх орны ирээдүй болсон дүү нартаа сурлагын өндөр амжилт хүсэж чадварлаг боловсон хүчин болж улс орны хөгжил цэцэглэлт, бүтээн байгуулалтанд үнэтэй хувь нэмэрээ оруулна гэдэгт итгэж байна.




Хэт Хүч ХХК

2018.09.28-нд 12:44 цагт

ИЗОУС-ийн харъяа Дүрслэх Урлаг Дизайн Технологийн Дээд Сургуулийн 2-р дамжааны оюутнууд үйлдвэртэй танилцах дадлага хийлээ. Монгол улсын хөгжил, цэцэглэлтийн түүчээ болсон залуус дүү нартаа сурлага, хөдөлмөрийн өндөр амжилт хүсье.



“Алтайн хүдэр” компанийн цахилгааны инженер Ж.Тулгатай 89455494 утсаар холбогдон, оюутан, суралцагчаа дадлагажуулах хүсэлтэй байгаагаа хэлсэн ба ТМБ – ын III жилийн УУЭТТ – ийн техникчийн ангийн оюутнууд үйлдвэрлэлийн дадлагаа хийх болон мэргэжлийн багш нар маань үйлдвэрлэлийн орчинтой танилцах боломжтой талаар санал, бодлоо солилцсон ба тухайн хүн маань ээлж амраад байгаа ба холбогдох алба хариуцсан даргатайгаа уулзаад албан ёсоор хариу өгөхөө мэдэгдсэн.

АЛТАЙН ХҮДЭР ХХК

# Алтайн Хүдэр ХХК

Үндэсний компани Монголын ирээдүй




7011-7991

hr05@altainkhuder...

http://www.altainkhuder.mn

fb://no content

tw://no content

# СУДАЛГААНЫ АСУУЛГА

## А. Аж ахуйн нэгж,байгууллагын инженер техникийн ажилтнаас авсан судалгааны асуулга

Түншлэгч байгууллага,үйлдвэр, аж ахуйн нэгж болон компаниас авах судлагааны асуулга
1. Дадлагажигч оюутан, суралцагчийг дадлага хийх эхний өдөр, танай байгууллага,байгууллагынхаа цех,тасаг, үйл ажиллагааны чиглэлтэй танилцуулдаг уу?

А. Байнга танилцуулдаг – 83% Б.Танилцуулдаггүй – 9% В.Танилцуулах шаардлагагүй – 8%

2. Тухайн суралцагчийн дадлагын удирдамжинд заагдсан, хийж гүйцэтгэх ажлуудыг бүрэн гүйцэд хийлгэж, та чадсан уу?

А.Бүрэн чадсан - 25% Б. Зарим зүйлсийг чадаагүй – 75%

3. Дадлага хийлгэх үед дадлагажигчийн суурь чадвар ямар байсан бэ?

А. Маш сайн байсан – 17%
Б.Дунд зэрэг – 50%
В.Тааруу байсан – 33%
4. Танай байгууллага Говьсүмбэр аймаг дахь Политехник коллежтэй түншлэгч байгууллага мөн үү?

А.Албан ёсны гэрээтэй - 17% Б.Гэрээ байгуулаагүй - 75%
В.Түншлэгч биш боловч дадлагажигчийг сургаж байсан - 8%

5.Дадлагажигчаар очсон суралцагчийн ямар мэдлэг, чадвар хангалтгүй байсан бэ?

А.Онолын суурь мэдлэг тааруу – 0% Б. Мэргэжлийн суурь чадвар сул тааруу – 100%

6. Тухайн дадлагажигчийн, мэргэжлийн суурь мэдлэг, чадвар тун тааруу байсан бол хэддүгээр курсын оюутан байсан бэ?

А. 1-р курс - 16% Б. 2-р курс - 42% В. 3-р курс - 42%

7. Дадлага хийж байгаа оюутанд онолын мэдлэг чухал уу, бодит чадвар чухал уу?

А.Онол - 0% Б.Чадвар - 8%
В. Онол, мэргэжлийн ур чадвар хоёулаа – 92%

8. Дадлагажигчийн хүмүүжил,төлөвшил, хариуцлага, хандлага хэр зэрэг байсан бэ?

А.Маш сайн байсан - 42% Б. Дунд зэрэг - 33%
В.Тун тааруу байсан – 25%

9. Дадлагажигч оюутан, суралцагчид хандан дадлагажуулагчийн зүгээс олгохоор зорьдог хамгийн чухал чадвар таны хувьд юу вэ? Давамгайлсан хариулт – Хандлага 16%

10. Дадлагажигч оюутан, суралцагчид таны олгосон мэргэжлийн мэдлэг, чадварын ахицын түвшин хэр болсон гэж та үзэх вэ?

А. Маш сайн - 0% Б.Сайн - 58%
В. Дунд зэрэг – 33% Г.Бага зэрэг - 8%

**Б. Дадлагажигчаас авсан судалгааны асуулга**

1. Үйлдвэрлэлийн дадлага хийх газраа яаж олсон бэ?
   А.Өөрөө олсон – 29%
   Б.Сургууль холбож өгсөн – 71%
2. Ямар байгууллага дээр үйлдвэрлэлийн дадлагаа хийж байсан бэ?
   А.Мэргэжлийн дагуу – 86%
   Б.Мэргэжлийн бус – 14%
3. Тухайн байгууллага дадлага хийх эхний өдөр, танд байгууллагынхаа цех, тасаг, үйл ажиллагааны чиглэлтэй танилцуулсан уу?
   А.Танилцуулсан – 90%
   Б.Танилцуулаагүй – 10%
4. Дадлага удирдагч, таны дадлагын удирдамжтай уншиж танилцсан уу?
   А.Уншсан – 95%
   Б.Уншаагүй – 5%
5. Онолоор сурсан мэдлэгээ, дадлага ажлын хүрээнд хэр зэрэг ахиулсан бэ?
   А.Маш сайн – 9%
   Б.Сайн – 52%
   В.Дунд зэрэг – 38%
6. Үйлдвэрлэлийн дадлага хийх явцад мэргэжлийн зүгээс нэн түрүүнд ямар, ямар чадвар, дадал чамд шаардагдсан бэ? /Хамгийн чухал гэсэн 3 чадварыг бичнэ үү?/
   А. Хабын дүрмийг мөрдөж ажиллах
   Б. Схем уншиж сурсан байх
   В. Холболт хийж сурсан байх
7. Үйлдвэрлэлийн дадлага хийсний үр дүнд эзэмшсэн хамгийн чухал чадвараа нэрлэн бичнэ үү?
   Тоолуур холбох, холболт хийх, монтаж хийж сурсан, багаар ажиллах, тосолгоо, аюулыг илэрүүлэх, анхааралтай байх
8. Дадлага хийх хугацаанд тухайн байгууллага болон дадлага удирдагчаас шалтгаалан үр дүнгүй өнгөрүүлсэн өдөр, хоног хэр олон байсан бэ?
   А.Олон байсан – 9%
   Б.Цөөн байсан – 57%
   В.Бүх өдөр үр дүнтэй байсан - 33%
9. Дадлага хийж байх хугацаандаа дадлага удирдагчийн шаардлагаар хийсэн онц шаардлагагүй, мэргэжлийн бус үр дүнгүй ажлуудаа нэрлэн бичээрэй? *
   Цэвэрлэгээ, будгийн ажил, ихэнх нь тийм ажил хийлгээгүй
10. Дадлага хийж байх хугацаандаа дадлага удирдагчийн шаардлагаар болон тухайн байгууллагын дотоод үйл ажиллагаанаас шалтгаалан хийсэн онц шаардлагагүй, мэргэжлийн бус дадлага ажлын удирдамжинд огт хамааралгүй ажлуудыг хэр их хийлгэдэг байсан бэ?
   А.Маш их – 0%
   Б.Дунд зэрэг – 14%
   В.Бага зэрэг – 57%
   Г.Огт хийлгэж байгаагүй – 28%
11. Үйлдвэрлэлийн дадлагын хүрээнд таны олж авсан мэргэжлийн мэдлэг, чадварын ахицын түвшин хэр болсон гэж үзэж байна вэ?
   А.Маш сайн – 33%
   Б.Дунд зэрэг – 57%
   В. Сайн – 5%
   Г. Одоо ч сурч байна – 5%
12. Хойшид энэ мэргэжилээрээ ажиллах уу?/Ажиллаж байгаа юу? *

   А.Ажиллана – 67%
   Б.Ажиллаж байгаа – 5%
   В.Ажиллахгүй – 14%
   Г. Тухайн үедээ болно – 7%
   Д. Ажиллахгүй байгаа – 7%

## Дүгнэлт

Барилгын оюутнуудын үйлдвэрлэлийн дадлагыг сайжруулахын тулд барилгын чиглэлийн үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж байгууллагуудтай уялдаа холбоогоо сайжруулж, албан ёсоор хамтран ажиллах гэрээ байгуулах, түншлэгч байгууллагынхаа хүрээг тэлэх нь сургалтын үйл ажиллагаа эрхэлдэг, манай байгууллагын хувьд цаг алдалгүй хийх нэн тэргүүний ажил болоод байна.

Мэргэжлийн багшийн зүгээс олгож буй үйлдвэрлэлийн дадлагат гарахын өмнөх мэдлэг,чадвар,хандлага тухайн оюутан суралцагчид үйлдвэр болон хувийн компани, аж ахуйн нэгжид гологдохооргүй байхад цаашид анхааран ажиллах нь чухал юм.

Дадлагажуулагч нь үйлдвэрлэлийн дадлагаар дамжуулан дадлагажигч оюутан,суралцагчид олгох мэдлэг,чадвар,хандлагыг ахиулахын зэрэгцээ хөдөлмөрийн зах зээл дээр эрэлт хэрэгцээтэй байгаа нарийн мэргэжлийг онолтой уялдуулан, ур чадварын түвшинг сайжруулахад анхааран ажиллах нь чухал хэдий ч албан ёсоор гэрээ байгуулаагүй байгууллагын хувьд энэ нь хариуцлагын тогтолцоог сулруулж байгаа юм.

Түншлэгч байгууллагаас авсан судалгааны дүнг ерөнхийд нь дүгнэж үзэхэд, бид цаашид барилгын салбарын үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж, байгууллага, хувийн компаниудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлэх анхааран ажиллах шаардлагатай байна.

Түншлэгч байгууллага руу явуулахын өмнө, дадлагажигч суралцагчийн харилцаа хандлага болоод мэргэжлийн мэдлэг, ур чадварын түвшинг сайжруулахад бодит үр дүн, сургалтын чанарын ахиц дэвшил хэрэгтэй байна.

Мэргэжлийн багшийн зүгээс ч гэсэн "Түншлэгч байгууллага" – руу дадлага хийхээр явах хүсэлтэй байгаа оюутан, суралцагчаас тусгайлан боловсруулсан чадамжийн нэгжийн гүйцэтгэлээр шалгалт аваад, тэнцсэн тохиолдолд, сургалтын албаны албан ёсны зөвшөөрөлтэйгөөр дадлагад гарах эрхийг олгож байх нь эргээд тухайн оюутан, суралцагч маш том үүрэг, хариуцлагыг давхар өөртөө ухамсарлах нь дамжиггүй.

Мөн цаашлаад түншлэгч байгууллагаа өргөжүүлэн тэлж, гэрээний дагуу харилцан хамтран ажиллавал эргэх холбоогоо нягт уялдаатай болгож, манай сургуулийн зүгээс мэргэжлийн багш нар маань тухайн байгууллагад чадварлаг мэргэжлийн оюутныг сурган, ур чадвартай дадлагажигчийг хүлээлгэн өгөх тал дээр хариуцлагатай ажиллах нь нэн тэргүүний зорилт байх нь цаашдын хамтын ажиллагааг тасралтгүй, чанартай үргэлжлүүлэхэд чухал түлхэц болно гэж үзэж байна.

Барилгын салбарын хөгжил хурдацтай хөгжиж байгаа өнөө үед, багж, тоног төхөөрөмж, техник технологийн хөгжилтэй хөл нийлүүлэн алхах чадварлаг мэргэжилтэн бэлтгэн гаргах нь, бидний алсаа харсан бодлого, төлөвлөлтийн эцсийн үр дүн байх болно.

БАРИЛГЫН ӨРГӨН МЭРГЭЖЛИЙН БАГШ Н. МАРТА
МОНГОЛ ХЭЛ - УРАН ЗОХИОЛЫН БАГШ Д. ДАШДУЛАМ

## Ном зүй


"Ажилтай, орлоготой монгол хүн" Үндэсний хөтөлбөр

Мэргэжлийн болон техникийн боловсролыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр 2016 - 2021

Мэргэжлийн боловсролын сургалтын тухай хууль

Хөдөлмөрийн яамны Мэргэжлийн боловсрол, сургалтын бодлого зохицуулалтын газар, Мэргэжлийн боловсрол, сургалтын статистик мэдээлэл, 2015-2016 оны хичээлийн 1 хагас жил, 2016 он

ХНХЯ-ны Мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагын багш нарын анхдугаар зөвлөгөөн

Ашигласан цахим хаяг:

1. www.google.mn
2. www.education.com

**Хавсралт:** Аж ахуйн нэгж,байгууллагын инженер техникийн ажилтнаас авсан судалгааны үр дүнг хувиар илэрхийлсэн график







Танай байгууллага, манай сургуультай хамтран ажиллах гэрээтэй юу?
Албан ёсны гэрээтэй
Гэрээ байхгүй
Гэрээ байхгүй ч дадлагажуулсан


Дадлагажигчийн ямар мэдлэг, чадвар хангалтгүй байсан бэ?
Онолын суурь мэдлэг сул 0%
Мэргэжлийн суурь сул 100%




**Дадлагажигчаас авсан судалгааны үр дүнг хувиар илэрхийлсэн график**




Дадлага хийх хугацаанд тухайн байгууллага болон дадлага удирдагчаас шалтгаалан үр дүнгүй өнгөрүүлсэн өдөр хэр олон байсан бэ?
Олон байсан
Цөөн байсан
Байгаагүй


Үйлдвэрлэлийн дадлагын хүрээнд эзэмшсэн мэдлэг, чадварын ахиц хэр болсон бэ?
Маш сайн
Сайн
Дунд зэрэг
Бага зэрэг

## Хойшид энэ мэргэжилээрээ ажиллах уу?



## Барилгын мэргэжлийн дагуу түншлэгч байгууллагуудын хүрээг тэлсэнээр үйлдвэрлэлийн дадлагын чанарт сайнаар нөлөөлөх нь

Илтгэгч багш нар:
БАРИЛГЫН ӨРГӨН МЭРГЭЖЛИЙН БАГШ Н. МАРТА
МОНГОЛ ХЭЛ - УРАН ЗОХИОЛЫН БАГШ Д. ДАШДУЛАМ

---

**Түлхүүр үгс:** Дадлага, түншлэгч байгууллага, багш, дадлагажуулагч, дадлагажигч

**Зорилго:** Үйлдвэрлэлийн дадлагыг мэргэжлийн байгууллага дээр нь албан ёсны гэрээтэйгээр хийлгэж, дадлагажигч оюутны мэргэжлийн ур чадварын ахицад анхаарах

**Зорилт:**

- Түншлэгч байгууллагуудын хүрээг тэлэх, харилцан хамтын ажиллагааны гэрээнд дадлагажигчийг чадваржуулах хөшүүрэг оруулах
- Үйлдвэрлэлийн дадлагаар чадварлаг оюутан бэлтгэхийн тулд цаашид сургалтын байгууллага, мэргэжлийн багш нарынхаа ур чадварт анхаарах нь
- Манай сургуулиас бэлтгэн гаргадаг Барилгын цахилгаан монтаж, Барилгын засал чимэглэл гэсэн хоёр мэргэжлийн ангийн дадлагажуулагч, дадлагажигчийн харилцан хамаарал, дадлага ажлын уялдаа холбоог мэдэхийн тулд асуулгын аргаар судалгаа авч дүгнэлт

2

---

❖ Онолын хэсэг

- Манай сургууль, бусад байгууллага хоорондын түншлэл, хамтын ажиллагаа ба үйлдвэрлэлийн дадлагын чанарт хэрхэн нөлөөлж буй байдал
- Техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалтын салбарт бий болоод байгаа ололт, амжилтууд
- Түншлэгч байгууллагуудын хүрээг тэлэх, харилцан хамтын ажиллагааг хэрхэн сайжруулах тухайд
- Үйлдвэрлэлийн дадлагаар чадварлаг оюутан бэлтгэхийн тулд цаашид сургалтын байгууллага, мэргэжлийн багш нарынхаа ур чадварт анхаарах нь

3

---

**1** **Манай сургууль, бусад байгууллага хоорондын түншлэл, хамтын ажиллагаа ба үйлдвэрлэлийн дадлагын чанарт хэрхэн нөлөөлж буй байдал**

Мэргэжлийн боловсрол, сургалтын салбарын шинэчлэл нь хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцүүлэх, төр, хувийн хэвшлийн түншлэлийн бодит механизм бүрдүүлж төлөвшүүлэх, үйлдвэрлэлийн хөгжлийн хэрэгцээтэй холбож төрөлжүүлэх, сургалтын стандарт, хөтөлбөрийг шинэчлэх, багш нарыг заах арга зүй болон мэргэшсэн инженер техникийн ажилтны түвшинд хүргэж чадваржуулах, үйлдвэрлэл-дадлагын сургалтын бааз, лабораторийг өрчин үеийн шаардлагад нийцүүлэх, сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүнээр хангах, иргэдийн хэрэгцээнд суурилсан үйлчилгээг нэвтрүүлэх, эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх асуудлыг хамарч байна хэмээн хөгжлийн хөтөлбөрт тусгасан байна.

5

Иймд МБС-ын салбар нь барилга, уул уурхай, хүнс хөдөө аж ахуй, аж үйлдвэр, зам тээвэр, үйлчилгээ зэрэг тэргүүлэх салбарт мэргэжилтэй ажилтны эрэлтийг хангаж, хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, эдийн засаг, нийгмийн тогтвортой хөгжлийг хангахад чухал түлхэц өгдөг салбар юм.

Манай сургуулиас бэлтгэн гаргадаг Барилгын цахилгаан монтаж, Барилгын засал чимэглэлийн энэ хоёр мэргэжлийн ангийн хувьд төгсөгчдийн дийлэнх нь хөдөлмөрийн зах зээл дээр, ажлын байрны олдоц хангалттай сайн байдаг хэдий ч дээрх мэргэжлээр бэлтгэгдэн гарч байгаа суралцагчид маань бодит байдал дээр дийлэнх нь буюу 75 – 85% мэргэжлийнхээ дагуу ажил, хөдөлмөр эрхэлж хараахан чадахгүй байгаа нь учир дутагдалтай байна.

6

Мэргэжлийн боловсролын хөгжлийн 2016 – 2021 оны хөтөлбөрт энэ тухай хэрхэн тусгасан байдаг тухайд

А. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцүүлэх

Б.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн бодит механизм бүрдүүлэх

МБСБ – аас гаргасан энэхүү бодлого шийдвэрийг бодит байдал дээр хангалттай сайн хэрэгжүүлж чадахгүй байгаа билээ. Учир нь Говьсүмбэр Политехник Коллежийн түншлэн ажиллаж буй аж ахуйн нэгж, байгууллагууд:

А. Beiben truck
Б. "Шивээ овоо" ХХК
В. "Мак цемент" ХХК
Г. "Гексаэдр клауд" ХХК
Д. "Говь Урал"
Е. "УСДУ"
Ё. "Замын III анги"

7

Дээрх байгууллагуудын ихэнх нь уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг бол ганцхан "Гексаэдр клауд" ХХК барилга угсралтын компани бөгөөд манай байгууллага түншлэлийн гэрээ байгуулаад удаагүй учраас тухайн компани дээр дадлага хийсэн оюутан, суралцагч одоогоор байхгүй.

Иймд барилгын ангийн суралцагчдад үйлдвэрлэлийн дадлагаа хийх түншлэгч байгууллага хангалттай байхгүй байгаа нь хамгийн нэн тэргүүнд үйлдвэрлэлийн дадлага чанаргүй болох, цаашлаад дадлагажигчийн мэргэжлийнхээ дагуу мэдлэг, ур чадвараа ахиулах боломжийг хаалттай болгож байгаа юм.

8



Дадлага ажлын энэхүү асуудлыг доорх видео бичлэгээр баримтжуулав.

Дадлага хийх газраа хэрхэн олж байсан тухайд болон дадлага ажлаараа юу, юу сурсаныг асууж тодруулсан

9

БЦМ – 3А анги, оюутан Э.Энхзул

III курсынхээ үйлдвэрлэлийн дадлагаар яг өөрийн сурдаг мэргэжлийн чиглэл дагуу "Материал трейд" ХХК дадлагаа хийсний үр дүнд, олон зүйлийг сурч, ур чадвараа ахиулсан байгаа



10

Хэдийгээр үйлдвэрлэлийн дадлагаа тухайн оюутан, суралцагч өөрөө, хувиараа аль нэг аж ахуйн нэгж, байгууллага юмуу хувийн компани дээр олж хийх тохиолдол давамгай байгаа боловч олон талаар ач холбогдол багатай нь бодит байдал дээр ажиглагдаж байдаг. Асуумж судалгааны үндсэн дээр эдгээрээс дурьдхад:

А. Мэргэжлийн хамааралгүй аж ахуйн нэгж, байгууллага дээр дадлагаа хийх WANT BIG IMPACT? USE BIG IMAGE.

Б. Мэргэжлийн бус хүнээр үйлдвэрлэлийн дадлагаа удирдуулах

В. Дадлага ажлын удирдамжинд заагдсан гол гол ажлыг хийж гүйцэтгэж үзэлгүй, дадлагын хугацааг дуусгах

Г. Тухайн дадлагажигчийг хариуцсан хүн мэргэжлийн мэдлэг, ур чадварыг нь ахиулах тал дээр анхаарч ажиллахгүй байх

Д. Дадлага ажлын хугацааг тогтоосон хугацаанаас цөөн хоногоор хийж, дадлага ажлын ач холбогдолыг сулруулах зэрэг дутагдалтай тал олон байна.

11

Үйлдвэрлэлийн дадлагаа чанаргүй, мэргэжлийн бус байгууллага дээр хийсэн оюутан, суралцагчид цаашид мэргэжлээрээ ажиллах дур сонирхолгүй болохоос гадна зарим талаар төгсөгч маань ажлын байран дээр гарлаа гэхэд ажил олгогчид гологдож байгаа нь бодит үнэн юм.

12

Техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалтын салбарт бий болоод байгаа ололт, амжилтууд

1.МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫН САЛБАРТ ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ТААТАЙ ОРЧИН БҮРДЭЖ БАЙНА. Техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалтын харилцааг 2002 он хүртэл "Боловсролын тухай" болон "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай" хуулийн хүрээнд зохицуулж ирсэн. УИХ 2002 онд "Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай" анхны бие даасан хуулийг батлан гаргаснаар техник, мэргэжлийн боловсрол, сургалтыг хөдөлмөрийн зах зээлд нийцүүлэх асуудалд анхаарал хандуулах болсон.

13

2. МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫГ ЧАДАМЖИД СУУРИЛСАН СУРГАЛТАД ШИЛЖҮҮЛЭН ХӨГЖҮҮЛЖ БАЙНА. МБС-ын салбарыг системээр нь өөрчлөн хөгжүүлэх, олон улсын түвшинд хүргэхэд ЧСС-ын тогтолцоог бүрдүүлэх асуудал тэргүүнд тавигдаж, олон улсын туршлагыг нэвтрүүлэх асуудлын хүрээнд томоохон донор байгууллагууд хамтран ажиллаж байна. Шинэчлэлийг эхлүүлэхэд АНУ-ын Мянганы сорилтын сангийн компакт гэрээний дагуу 2008-2012 онд төсөл хэрэгжиж үнэтэй хувь нэмэр оруулсан.

Мэргэжлийн болон техникийн боловсролыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр 2016 - 2021

14

3. НИЙГМИЙН ТҮНШЛЭЛ, ХАМТЫН АЖИЛЛАГАА САЙЖИРЧ БАЙНА. Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 2009 онд хийсэн шинэчилсэн найруулгаар Мэргэжлийн боловсрол, сургалтын талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэхэд төр, хувийн хэвшлийн тэнцүү оролцоог хангасан Үндэсний зөвлөл байгуулж, тус зөвлөл нь МБС-ын дээд удирдлагыг хэрэгжүүлнэ гэж хуульчилсан.

15

**Түншлэгч байгууллагуудын хүрээг тэлэх, харилцан хамтын ажиллагааг хэрхэн сайжруулах тухайд**

Чадамжид суурилсан сургалтын гол зарчим нь мэргэжлийн ур чадварыг академик онолоос илүүтэй дадлага ажил, практик сургалтанд суурилан орчин үеийн технологид нийцсэн дадлагын орчинд тоног төхөөрөмж багаж, хэрэгсэлд гараар хүрч ажиллан бодитоор мэдрэн сурах замаар олгоход чиглэдэг тул төгсөгч бэлтгэн гаргадаг мэргэжлийнхээ дагуу түншлэгч байгууллагуудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлэхэд анхааран ажиллах нь бидний хамгийн ойрын зорилт байх ёстой гэж үзэж байна.

16

Сургууль дээр явагдаж байгаа дадлага ажлын цаг ч гэсэн онолын мэдлэгийг 20 хувь, дадлага ажлаас олж авах мэдлэгийг 80 хувьд хүргэхэд анхаарч сургалтаа явуулах нь чухал байгаа юм.

Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөөр 50-иас дээш ажилтантай аж ахуйн нэгж суралцагчийн үйлдвэрлэлийн дадлагын ажлыг зохион байгуулж, удирдан чиглүүлэх үүрэг бүхий дадлагажуулагч багш ажиллуулна гэж заасан байдаг байна.

Энэхүү хуулийн заалтын хэрэгжилт бодит байдал дээр хэрэгжихгүй байгаа боловч дадлагын сургалтын чанарыг сайжруулахад анхааран ажиллах ажлын хүрээнд аж ахуйн нэгж байгууллагад, сургууль хамтран ажиллах санал тавин, түншлэлийн гэрээ байгуулан ажиллах нь чухал билээ.

17

Аливаа нэгэн томоохон нэр хүнд бүхий байгууллагатай түншлэлийн гэрээ байгуулахын өмнө тухайн байгууллагаас дадлагажигч оюутан, суралцагчаас ямар харилцаа, хандлагатай, өөрийн сурдаг мэргэжлийн түвшинд ямар мэдлэг, ур чадвартай байх шалгуур тавьж байгааг албан бичгээр дамжуулан авч, улмаар тэрхүү шалгуурт тэнцсэн дадлагажигчийг тухайн байгууллагад түншлэлийн гэрээний дагуу үйлдвэрлэлийн дадлага хийлгэж байх нь хамтын ажиллагааны гэрээгээр хүлээсэн үүрэгт болоод түншлэгч хоёр байгууллагын харилцан итгэлцэл, цаашдын хамтын ажиллагаанд сэв суухгүй байх зэрэг давуу тал олон байгаа юм.

18

Түншлэгч байгууллага руу гэрээгээр дадлага хийх оюутан, суралцагчид сургууль дотоод журмаар зохицуулалт хийн, тодорхой шалгуур тавьж, цэнзүүртэйгээр буюу шалгарсан оюутан, суралцагч байвал тухайн байгууллага дээр очоод харилцаа хандлага болоод хариуцлага сайтай, тодорхой мэргэжлийнхээ түвшинд онолын болоод ур чадварын түвшингээр гологдохооргүй байдлыг харгалзан үзэж гэрээ байгуулсаны үндсэн дээр дадлагад гаргах нь цааш цаашдын хамтын ажиллагааг тасралтгүй үргэлжлүүлэх, өргөжүүлэхэд чухал алхам болно гэж үзэж байна.

19

Мэргэжлийн багшийн зүгээс ч гэсэн "Түншлэгч байгууллага" – руу дадлага хийхээр явах хүсэлтэй байгаа оюутан, суралцагчаас тусгайлан боловсруулсан чадамжийн нэгжийн гүйцэтгэлээр шалгалт аваад, тэнцсэн тохиолдолд, сургалтын албаны албан ёсны зөвшөөрөлтэйгөөр дадлагад гарах эрхийг олгож байх нь эргээд тухайн оюутан, суралцагч маш том үүрэг, хариуцлагыг давхар өөртөө ухамсарлах нь дамжиггүй.

Илтгэлийнхээ судалгааны ажлаар хэд хэдэн хүнтэй холбогдож, сургуулийнхаа сургалтын чиглэл, үйл ажиллагааны чиглэлийг танилцуулсаны үр дүнд мэргэжлийн багш нар болон оюутан, суралцагч нараасаа дадлагажуулах хүсэлтэй байгаагаа уламжилсаны үр дүнд дараах хувийн хэвшлийн компаниуд хамтран ажиллах хүсэлтийг маань хүлээн авсан таатай мэдээг дуулгахад сайхан байна.

20


Шивээ-Овоо ХК нь 1990 онд байгуулагдсан, Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын нутагт байршилтай стратегийн ач холбогдолтой Шивээ-Овоогийн хүрэн чулууны нүүрсний уурхайгаас нүүрс олборлодог, Монгол улсын дотоодын эрчим хүчний нүүрсний хэрэглээний 28.3%-ийг нийлүүлж, Монгол улсын Эрчим хүчний 70.0%-ийг дангаараа үйлдвэрлэдэг "ДЦС-4" ТӨХК-ийн нүүрсний хэрэглээний 51.0%-ийг хангадаг ба "ДЦС-3", Амгалан дулааны станц, Бор-Өндөр УБҮ, Дорноговь, Говьсүмбэр, Төв аймаг, Сэлэнгэ зэрэг цахилгаан, дулааны станцуудад нүүрсээ нийлүүлдэг.
Шивээ-Овоо ХК
Хуулийн эрх зүйн хэлбэр
Хувьцаат компани (Монголын хөрөнгийн бирж, [1][2]
Үүсгэн байгуулагдсан
1990 он
Төв байр
Говьсүмбэр аймгийн Шивээговь сум,
21


Материал Трейд ХХК updated their profile picture.
22


Бидний тухай
23


Алтайн Хүдэр ХХК
2011-7991
http://www.altainkhuder.mn
fb://no content
tw://no content
24




25

**Үйлдвэрлэлийн дадлагаар чадварлаг оюутан бэлтгэхийн тулд цаашид сургалтын байгууллага, мэргэжлийн багш нарынхаа ур чадварт анхаарах нь**

Бүх салбарт багшид тавьж буй мэдлэг, ур чадвар, заах арга зүйн шаардлага шинэчлэгдэж байна. Манай мэргэжлийн боловсрол сургалтын багш л гэхэд аж ахуйн нэгж дэх инженер техникийн ажилтантай дүйхүйц, түүнээс илүү түвшний мэдлэг, мэргэшлийн ур чадвартай, бизнес сэтгэлгээтэй, сургах зүйн идэвхитэй, бүтээлч аргуудыг эзэмшсэн, өндөр ёс зүйтэй байх шаардлагад нийцэх хэрэгтэй байна.

26

Яг өнөөгийн нөхцөлд манай багш нарын мэдлэг, ур чадвар, туршлага өнөөгийн шаардлагаас хоцронгуй, үйлдвэр аж ахуйн газарт мэргэшил дээшлүүлэх боломж хязгаарлагдмал байгаа нь багшийн чадвар, сургалтын чанарт сөргөөр нөлөөлж байгааг хүлээн зөвшөөрөхөөс аргагүй.

Иймд зөвхөн оюутан, суралцагчийг дадлагажуулж, чадваржуулах тухай яриад байх нь өрөөсгөл ойлголт юм. Тухайн мэргэжлийн багшаа сургалтын байгууллагын зүгээс мэргэшлийн чиглэл таарсан, тухайн салбарт шинэ дэвшилтэт техник, технологиор үйл ажиллагаа, үйлчилгээ явуулдаг аж ахуйн нэгж, байгууллага, компанитай хамтран ажиллаж үр дүнд хүрч болох юм.

27

Жишээ нь:

- ✓ Туршлага судлуулах
- ✓ Багш солилцооны нэг сарын хөтөлбөр хэрэгжүүлэх
- ✓ Цахилгаан станц дээрх техник, тоног төхөөрөмжтэй танилцуулах
- ✓ Барилга угсралтын компаны шинэ дэвшилтэт арга туршлагатай танилцуулах
- ✓ Барилгын дотоод засал чимэглэлийн шинэ дэвшилтэт техник технологи, багж тоног төхөөрөмж дээр ажиллах туршлага хуримтлуулах
- ✓ Үйлдвэр, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаатай танилцах
- ✓ Барилгын мэргэжлийн багшийг барилгын дотоод засал чимэглэл хийж байгаа барилгын компани дээр ур чадварын түвшин ахиулах дадлага хийлгүүлэх
- ✓ Үйлдвэр, аж ахуйн нэгж, томоохон уурхай, хувийн компаны үйл ажиллагаатай танилцуулах хөтөлбөр хэрэгжүүлэх
- ✓ Цахилгааны холболт, угсралтын компанид очиж, туршлага судлах гэх зэргээр мэргэжлийн багшаа ажил мэргэжлийн талбар дээр хөгжих, мэргэжлийн дагуу ур чадвараа ахиулах тал дээр санаачлага гарган, дэмжин ажиллах нь чухал билээ.

28

Хөгжсөн багшаас, хөгжсөн суралцагч төрөн гарах нь дамжиггүй юм. 2020 онд манай байгууллага шинээр хамтран ажиллах гэрээ байгуулсан "Гексаэдр клауд" ХХК нь цахилгааны холболт, угсралтын үйл ажиллагаа эрхэлдэг ба түншлэлийн гэрээнийхээ дагуу очиж, мэргэжлийн багш нь дадлагажигч оюутан, суралцагчийг ямар, хөтөлбөрийн дагуу сургаж, бэлтгэдэг болон үйлдвэрлэлийн дадлагад гарахын өмнө тухайн оюутан, суралцагчид багшийн зүгээс ямар ямар мэргэжлийн мэдлэг, ур чадварыг эзэмшүүлдэг тухайгаа танилцуулаад, цаашид тухайн компани дээрх үйлдвэрлэлийн дадлагаар хэрхэн чадваржуулах хүсэлтэй байгаагаа танилцуулах зэргээр харилцан зөвшилцөлд хүрэх зэргээр уялдаатай ажиллаж чадвал дадлагажигч оюутан, суралцагчийн үйлдвэрлэлийн дадлагаас олж авах мэдлэг, ур чадварт маш их ахиц гаргана гэж найдаж байна.

29

**Судалгааны зорилго**

ГСА-ПТК-ийн сургуулиас бэлтгэн гаргадаг барилгын цахилгаан монтаж,барилгын засал чимэглэл гэсэн хоёр мэргэжлийн ангийн үйлдвэрлэлийн дадлагын чанарыг ахиулахын тулд дадлагажуулагч,дадлагажигчийн уялдаа холбоог хойшид сайжруулахад юунд анхааран ажиллах талаар асуулгын аргаар судлагаа авч, дүн шинжилгээ хийхэд оршино.

30

**Судалгааны арга зүй**

Энэхүү судалгаандаа бид, аж ахуйн нэгж, оюутнууд гэсэн хоёр субьектийг сонгож, нийт 12 аж ахуйн нэгжийн албан тушаалтан, 21 суралцагчийг судалгаанд хамруулж, нээлттэй асуулгын хэлбэрээр "Google docs" программыг ашиглан түүврийн аргаар судалгаа явуулсан. Мөн томоохон уул уурхайн компанийн цахилгааны инженерүүдтэй утсаар холбогдон илтгэлийн сэдвийн хүрээнд гол гол зүйлсийг асууж тодруулсан.

Ажлын байран дээрээ гаргасан холбогдох "Мөшгих судалгаа" болон оюутан, суралцагчдын үйлдвэрлэлийн тайлан хамгаалах үйл явц, тэдний ур чадварын өсөлт, ололт амжилт дээр байнга практик ажиглалтыг хийж байсан зэрэг туршлага дээрээ үндэслэн энэхүү сэдвийг хөндөн бичсэн ба судалгааны асуулгаа боловсруулж, сэдвийн гол санаа, дүгнэлтээ гаргахад хуримтлуулсан туршлага маань чухал нөлөөтэй байлаа.

31

**Судалгаанаас гарсан үр дүн**

- Тухайн суралцагчийн дадлагын удирдамжинд заагдсан, хийж гүйцэтгэх ажлуудыг бүрэн гүйцэд хийлгэж чадаагүй гэж 75% нь хариулсан.
- Дадлагажуулагч, дадлага хийлгэх явцдаа дадлагажигчийн суурь чадварыг дунд зэрэг байсан гэж 50% үнэлсэн байна.
Говьсүмбэр аймаг дахь Политехник коллежтэй албан ёсны гэрээтэй түншлэгч байгууллага мөн гэж - 17% хариулсан.
- Дадлагажигчаар очсон суралцагчийн, мэргэжлийн суурь чадвар сул тааруу, хангалтгүй байсан гэж судалгаанд оролцогчид – 100% бөглөсөн байна.
- Дадлагажигч оюутан, суралцагчидыг, таны олгосон мэргэжлийн мэдлэг, чадварын ахицын түвшин нь хэр болсон гэсэн асуумжинд маш сайн гэж хариулсан хүн байхгүй, сайн - 58, дунд зэрэг – 33%, бага зэрэг гэж - 8% нь хариулсан байна.

32

## ДҮГНЭЛТ

Барилгын оюутнуудын үйлдвэрлэлийн дадлагыг сайжруулахын тулд барилгын чиглэлийн үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж байгууллагуудтай уялдаа холбоогоо сайжруулж, албан ёсоор хамтран ажиллах гэрээ байгуулах, түншлэгч байгууллагынхаа хүрээг тэлэх нь сургалтын үйл ажиллагаа эрхэлдэг, манай байгууллагын хувьд цаг алдалгүй хийх нэн тэргүүний ажил болоод байна.

Мэргэжлийн багшийн зүгээс олгож буй үйлдвэрлэлийн дадлагат гарахын өмнөх мэдлэг,чадвар,хандлага тухайн оюутан суралцагчид үйлдвэр болон хувийн компани, аж ахуйн нэгжид гологдохооргүй байхад цаашид анхааран ажиллах нь чухал юм.

33

Дадлагажуулагч нь үйлдвэрлэлийн дадлагаар дамжуулан дадлагажигч оюутан,суралцагчид олгох мэдлэг,чадвар,хандлагыг ахиулахын зэрэгцээ хөдөлмөрийн зах зээл дээр эрэлт хэрэгцээтэй байгаа нарийн мэргэжлийг онолтой уялдуулан, ур чадварын түвшинг сайжруулахад анхааран ажиллах нь чухал хэдий ч албан ёсоор гэрээ байгуулаагүй байгууллагын хувьд энэ нь хариуцлагын тогтолцоог сулруулж байгаа юм.

Түншлэгч байгууллагаас авсан судалгааны дүнг ерөнхийд нь дүгнэж үзэхэд, бид цаашид барилгын салбарын үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж, байгууллага, хувийн компаниудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлэхэд анхааран ажиллах шаардлагатай байна.

34

Түншлэгч байгууллага руу явуулахын өмнө, дадлагажигч суралцагчийн харилцаа хандлага болоод мэргэжлийн мэдлэг, ур чадварын түвшинг сайжруулахад бодит үр дүн, сургалтын чанарын ахиц дэвшил хэрэгтэй байна.

Мэргэжлийн багшийн зүгээс ч гэсэн "Түншлэгч байгууллага" – руу дадлага хийхээр явах хүсэлтэй байгаа оюутан, суралцагчаас тусгайлан боловсруулсан чадамжийн нэгжийн гүйцэтгэлээр шалгалт аваад, тэнцсэн тохиолдолд, сургалтын албаны албан ёсны зөвшөөрөлтэйгөөр дадлагад гарах эрхийг олгож байх нь эргээд тухайн оюутан, суралцагч маш том үүрэг, хариуцлагыг давхар өөртөө ухамсарлах нь дамжиггүй.

35

Мөн цаашлаад түншлэгч байгууллагаа өргөжүүлэн тэлж, гэрээний дагуу харилцан хамтран ажиллавал эргэх холбоогоо нягт уялдаатай болгож, манай сургуулийн зүгээс мэргэжлийн багш нар маань тухайн байгууллагад чадварлаг мэргэжлийн оюутныг сурган, ур чадвартай дадлагажигчийг хүлээлгэн өгөх тал дээр хариуцлагатай ажиллах нь нэн тэргүүний зорилт байх нь цаашдын хамтын ажиллагааг тасралтгүй, чанартай үргэлжлүүлэхэд чухал түлхэц болно гэж үзэж байна.

Барилгын салбарын хөгжил хурдацтай хөгжиж байгаа өнөө үед, багж, тоног төхөөрөмж, техник технологийн хөгжилтэй хөл нийлүүлэн алхах чадварлаг мэргэжилтэн бэлтгэн гаргах нь, бидний алсаа харсан бодлого, төлөвлөлтийн эцсийн үр дүн байх болно.

36

Ном зүй
"Ажилтай, орлоготой монгол хүн" Үндэсний хөтөлбөр
Мэргэжлийн болон техникийн боловсролыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр 2016 - 2021
Мэргэжлийн боловсролын сургалтын тухай хууль
Хөдөлмөрийн яамны Мэргэжлийн боловсрол, сургалтын бодлого зохицуулалтын газар, Мэргэжлийн боловсрол, сургалтын статистик мэдээлэл, 2015-2016 оны хичээлийн 1 хагас жил, 2016 он
ХНХЯ-ны Мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагын багш нарын анхдугаар зөвлөгөөн

Ашигласан цахим хаяг
www.google.mn
www.education.com


37

**Тухайн суралцагчийн дадлагын удирдамжинд заагдсан, хийж гүйцэтгэх ажлуудыг бүрэн гүйцэд хийлгэж, та чадсан уу?**




38



39




40


Дадлагажигчийн ямар мэдлэг, чадвар хангалтгүй байсан бэ?
суурь сул
100%
41


Дадлага ажлын хүрээнд таны олгосон мэдлэг, чадварын ахиц хэр болсон бэ?
8%
33%
59%
Сайн
Дунд зэрэг
Бага зэрэг
42


Онолоор сурсан мэдлэгээ дадлага ажлын хүрээнд хэр ахиулсан бэ?
Маш сайн
Сайн
Дунд зэрэг
43


Дадлага хийх хугацаанд тухайн байгууллага болон дадлага удирдагчаас шалтгаалан үр дүнгүй өнгөрүүлсэн өдөр хэр олон байсан бэ?
Олон байсан
Цөөн байсан
Байгаагүй
44


Үйлдвэрлэлийн дадлагын хүрээнд эзэмшсэн мэдлэг, чадварын ахиц хэр болсон бэ?
Маш сайн
Сайн
Дунд зэрэг
Бага зэрэг
45


Хойшид энэ мэргэжлээрээ ажиллах уу?
70
60
50
40
30
20
10
0
Ажиллана
Ажиллаж байгаа
Ажиллахгүй
Тухайн үедээ шийднэ
Series 1
46


Анхаарал хандуулсанд баярлалаа
47

## Илтгэл тавьсан Авто засварын багш Д.Эрдэнэ –очир.

ЗОРИЛГО:Түншлэлд суурилсан үйлдвэрлэлийн дадлагыг чанаржуулах.

Туршлага: 2008,2009,2010 онуудад дадлага удирдсан багшаар ажиллаж 2015 онд Герман улсад мэргэжил дээшлүүлсэн туршлагадаа тулгуурлан энэхүү илтгэлийг бичив. Үйлдвэрлэлийн дадлага зохион байгуулахад дутагталтай 3 хүчин зүйл байна.

## Судалгаа

- Үйлдвэрлэлийн дадлага,элсэлтийг хариуцсан О.Н.Х.Албатай болохыг дэмжиж байна уу?
- 1.Тийм 2. үгүй
- Сургууль дээрхи дадлагын тоног төхөөрөмж,багаж хэрэгсэл,агрегат эд анги,түүний арчилгаа үйлчилгээний материал хүрэлцээ байнауу?
- 1.Тийм 2.үгүй
- Үйлдвэрлэлийн дадлагад гаргахад мэргэжилийн багш дадлагжуулагч багшаар хариуцаж дагаж явахыг дэмжиж байнауу?
- 1.тийм 2.үгүй
- ХММ-н Операторын дадлагын полигонтой болохыг дэмжиж байна уу?
- 1.тийм 2. Үгүй
- Тайлбар:Энэхүү судалгааг мэргэжилийн багш нараас авсан боловч ковидоос шалтгаалан маш цөөхөн багш оролцсон болно.

- 1.Олон нийттэй харилцах алба,эсвэл нийгмийн түншлэлтэй харилцах албатай болох./ гадаад дотоод харилцаа,элсэлт, төгсөлт/ хариуцсан.
- 2.Үйлдвэрлэлийн дадлагад сургуулиас дадлага удирдах мэргэжилийн багш явуулах.
- 3.Сургууль дээрхи дадлагыг чанартай болгох материаллаг баазаар хангах.
- Үйлдвэрлэлийн дадлага зохион байгуулах комисстой болох Үүнд: төрөл бүрийн мэргэжилийн багш нараас хамруулах.

## Шийдвэрлэх арга :

- Олон нийттэй харилцах алба нийгмийн түншлэлтэй харилцах алба гадаад дотоодтой харилцах алба болгож хүн хүчээ нэгтгэж элсэлт төгсөлтөө хариуцсан судалгаа,сурталчилгаа, үйлдвэрийн газар,аж ахуйн нэгж байгууллагатай гэрээ хийх зэрэг ажилуудыг ажил үүргийн хувиарт нь оруулж өгөх хэрэгтэй. Гэрээ хийхэд анхаарах хүчин зүйлүүд:
- 1.Хоол унааны зардалыг хэн нь хариуцах талаар тохиролцоонд хүрэх
- 2.Дадлагын багшийн томилолтын зардалыг төсөвт суулгах
- 3.Дадлагын удирдамжийн дагуу дадлага хийлгэх талаар тохиролцох

## Сургууль дээрхи дадлагыг чанартай болгохын тулд:

1.Материаллаг бааз агрегат эд ангийн тоог нэмэгдүүлэх

2.Мэргэжилийн багшийн тоог нэмэгдүүлэх

3.Нэг багшид ноогдох дадлага хийх оюутны тоог стандартын дагуу тогтоох

## Сургууль дээрхи дадлагыг чанартай болгохын тулд дадлагын полигонтой болох

- ХММО, УУ-н ашиглалтын техникчийн ангийн оюутнуудад дадлага хийх бичил орчин (полигон) бий болгох.
- 5.Дадлага хийх бага оворын техникүүдтэй болох Экскаватор,бульдозер,дугуйт ачигч,гэх мэт.
- Үүнд: Үйлдвэрийн дадлага хийж байгаа оюутнууд уул уурхай дээр очоод овоолго,мөргөцөг,догол,уурхайн орох гарах ам, хүнд даацын авто машины зам, механизмын зам гэх мэт зүйлүүдыг онолын хувьд мэддэг ч дадлагын хувьд танидаггүй ялгадаггүй учираас дадлагын полигон бий болговол сургууль дээрхи дадлагын чанар үр дүнтэй оюутнууд үйлдвэр дээр гархад ямар ч асуудалгүй хаана ч гологдохгүй мэргэшсэн ажилтан болох ёстой гэж үзэж байна.

- Герман улсын дадлагын полигон нь өглөө дадлагын хичээл эхлэнгүүт ухах ачих, тэгшлэх овоолго хийх, замын далан хэлбэржүүлэх гэх мэт ажилууддыг нэгэн зэрэг үйлдвэрлэлийн горимоор явуулдаг бөгөөд орой дадлагын хичээл тархад бүх ухсан нүх шороог индүүдэж тэгшлээд маргаашын дадлагын хичээлд бэлэн болгож орхидог юм билээ. Хэрэв аймаг орон нутгаас дэмжлэг үзүүлээд 1-2 га газар олговол зардал чирэгдэлгүйгээр мэргэжилийн багш оюутнуудын хүчээр дадлага хийх зарчимаар полигонтой болох боломж байна гэж үзэж байна.

- Тэсэлгээний зөвшөөрөл авч чадвал тэсэлгээний ангид ч дадлагын орчин бий болгож болно.Төгсөгчидын сургалтын чанар дээшилж үйлдвэрлэлийн дадлагын чанар ч мөн адил үр дүнтэй болно.
- Чанартай сургалтын дадлагын орчин бий болгож чадвал үйлдвэр дээр асуудалгүй гараад ажиллах чадвартай төгсөгчидыг бэлтгэж болно.
- Элсний,хайрганы,нүүрсний гэхчилэн бичил карьер байгуулбал өөрийн үйл ажиллагааны орлого олох түүгээрээ карьераа санхүүжүүлэх,няравын ангид дадлагын орчин бий болгох гэх мэтчилэн олон давуу талуудыг бий болгох сайн талуудтай.

- Техник технологийн зардалыг үйлдвэр сургалтын гөсөвт жил бүр суулгаад яваад байвал болмоор юм шиг , дадлагын эд анги, агрегат цэргүүдэд дадлага хийлгээд бараг бүтэн юм байхгүй болсон. Зөвхөн үзүүлэнгүүд л байгаа.Үүнийг тэнхимийн бус цагийн тооцоонд оруулах, эсвэл уралдаан урамшуулал зарлаад эд анги агрегатыг бүрдүүлж болох талтай.Хэрэв иймэрхүү зарчимаар сургууль дээрхи дадлагын хичээлийн материаллаг баазыг бүрдүүлж чадвал орон нутагтаа төдийгүй улсадаа анхдагч поигонтой дадлагын материаллаг баазтай сургууль болж элсэлт хүртэл сайжрах талтай. Ер нь сургууль дээрхи дадлагыг үйлдвэр дээрхи дадлагтай ойртуулах гэсэн зарчимийг баримтлах хэрэгтэй.

Үйлдвэрлэлийн дадлагад сургуулиас дадлага удирдах мэргэжилийн багш томилж явуулах.

- Дадлага удирдсан багш нарyданд тохирсон ХАБЭА-н зааварчилгаа өгдөг байх
- 2.Үйлдвэрийн газар АА.Нэгжүүд оюутнуудыг зөвхөн цэвэрлэгээ үйлчилгээний ажил хийлгэдэг мэргэжилийн ажилд томилдоггүй сул талтай учир дадлага удирдсан багш мэргэжилийн ажилд томилуулах түүнд таарсан ажлын наряд өгөх, аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөх зэрэг давуу талтай.
- 3.Мөн оюутнуудын хоол унаа,чөлөө зөвшөөрөл аюулгүй байдлыг багш өөрөө газар дээр нь шийдэх давуу талтай.

Илтгэл тавьсан Авто засварын багш Д.Эрдэнэ –очир.

ЗОРИЛГО:Түншлэлд суурилсан үйлдвэрлэлийн дадлагыг чанаржуулах.

Судалгаа

Үйлдвэрлэлийн дадлага,элсэлтийг хариуцсан О.Н.Х.Албатай болохыг дэмжиж байна уу?

1.Тийм 2. үгүй

Сургууль дээрхи дадлагын тоног төхөөрөмж,багаж хэрэгсэл,агрегат эд анги,түүний арчилгаа үйлчилгээний материал хүрэлцэж байнауу?

1.Тийм 2.үгүй

Үйлдвэрлэлийн дадлагад гаргахад мэргэжилийн багш дадлагжуулагч багшаар хариуцаж дагаж явахыг дэмжиж байнауу?

1.тийм 2.үгүй

ХММ-н Операторын дадлагын полигонтой болохыг дэмжиж байна уу?

1.тийм 2. Үгүй

Тайлбар:Энэхүү судалгааг мэргэжилийн багш нараас авсан боловч ковидоос шалтгаалан маш цөөхөн багш оролцсон болно.

Туршлага: 2008,2009,2010 онуудад дадлага удирдсан багшаар ажиллаж 2015 онд Герман улсад мэргэжил дээшлүүлсэн туршлагадаа тулгуурлан энэхүү илтгэлийг бичив.

Үйлдвэрлэлийн дадлага зохион байгуулахад дутагталтай 3 хүчин зүйл байна.

1.Олон нийттэй харилцах алба,эсвэл нийгмийн түншлэлтэй харилцах албатай болох./ гадаад дотоод харилцаа,элсэлт, төгсөлт/ хариуцсан.

2.Үйлдвэрлэлийн дадлагад сургуулиас дадлага удирдах мэргэжилийн багш явуулах.

3.Сургууль дээрхи дадлагыг чанартай болгох материаллаг баазаар хангах.

Үйлдвэрлэлийн дадлага зохион байгуулах комисстой болох Үүнд: төрөл бүрийн мэргэжилийн багш нараас хамруулах.

Шийдвэрлэх хүчин зүйл:

- Олон нийттэй харилцах алба нийгмийн түншлэлтэй харилцах алба гадаад дотоодтой харилцах алба болгож хүн хүчээ нэгтгэж элсэлт төгсөлтөө хариуцсан судалгаа,сурталчилгаа, үйлдвэрийн газар,аж ахуйн нэгж

байгуулагатай гэрээ хийх зэрэг ажилуудыг ажил үүргийн хувиарт нь оруулж өгөх хэрэгтэй. Гэрээ хийхэд анхаарах хүчин зүйлүүд:

1.Хоол унааны зардалыг хэн нь хариуцах талаар тохиролцоонд хүрэх

2.Дадлагын багшийн томилолтын зардалыг төсөвт суулгах

3.Дадлагын удирдамжийн дагуу дадлага хийлгэх талаар тохиролцох

- Сургууль дээрхи дадлагыг чанартай болгохын тулд:

1.Материаллаг бааз агрегат эд ангийн тоог нэмэгдүүлэх

2.Мэргэжилийн багшийн тоог нэмэгдүүлэх

3.Нэг багшид ноогдох дадлага хийх оюутны тоог стандартын дагуу тогтоох

- Дадлагын полигонтой болох

4.ХММО, УУ-н ашиглалтын техникчийн ангийн оюутнуудад дадлага хийх бичил орчин (полигон) бий болгох.

5.Дадлага хийх бага оворын техникүүдтэй болох Экскаватор,бульдозер,дугуйт ачигч,гэх мэт.

Үүнд: Үйлдвэрийн дадлага хийж байгаа оюутнууд уул уурхай дээр очоод овоолго,мөргөцөг,догол,уурхайн орох гарах ам, хүнд даацын авто машины зам, механизмын зам гэх мэт зүйлүүдыг онолын хувьд мэддэг ч дадлагын хувьд танидаггүй ялгадаггүй учираас дадлагын полигон бий болговол сургууль дээрхи дадлагын чанар үр дүнтэй оюутнууд үйлдвэр дээр гархад ямар ч асуудалгүй хаана ч гологдохгүй мэргэшсэн ажилтан болох ёстой гэж үзэж байна. Герман улсын дадлагын полигон нь өглөө дадлагын хичээл эхлэнгүүт ухах ачих, тэгшлэх овоолго хийх, замын далан хэлбэржүүлэх гэх мэт ажилууддыг нэгэн зэрэг үйлдвэрлэлийн горимоор явуулдаг бөгөөд орой дадлагын хичээл тархад бүх ухсан нүх шороог индүүдэж тэгшлээд маргаашын дадлагын хичээлд бэлэн болгож орхидог юм билээ. Хэрэв аймаг орон нутгаас дэмжлэг үзүүлээд 1-2 га газар олговол зардал чирэгдэлгүйгээр мэргэжилийн багш оюутнуудын хүчээр дадлага хийх зарчимаар полигонтой болох боломж байна гэж үзэж байна. Техник технологийн зардалыг үйлдвэр сургалтын төсөвт жил бүр суулгаад яваад байвал болмоор юм шиг , дадлагын эд анги, агрегат цэргүүдэд дадлага хийлгээд бараг бүтэн юм байхгүй болсон. Зөвхөн үзүүлэнгүүд л байгаа.Үүнийг тэнхимийн бус цагийн тооцоонд оруулах, эсвэл уралдаан урамшуулал зарлаад эд анги агрегатыг бүрдүүлж болох талтай.Хэрэв иймэрхүү зарчимаар сургууль дээрхи дадлагын хичээлийн материаллаг баазыг бүрдүүлж чадвал орон нутагтаа төдийгүй улсадаа анхдагч поигонтой дадлагын материаллаг баазтай сургууль болж элсэлт хүртэл сайжрах талтай. Ер нь сургууль дээрхи дадлагыг үйлдвэр дээрхи дадлагтай ойртуулах гэсэн зарчимийг баримтлах хэрэгтэй. Тэсэлгээний зөвшөөрөл авч чадвал

тэсэлгээний ангид ч дадлагын орчин бий болгож болно.Төгсөгчидын сургалтын чанар дээшилж үйлдвэрлэлийн дадлагын чанар ч мөн адил үр дүнтэй болно.

Чанартай сургалтын дадлагын орчин бий болгож чадвал үйлдвэр дээр асуудалгүй гараад ажиллах чадвартай төгсөгчидыг бэлтгэж болно.

Элсний,хайрганы,нүүрсний гэхчилэн бичил карьер байгуулбал өөрийн үйл ажиллагааны орлого олох түүгээрээ карьераа санхүүжүүлэх,няравын ангид дадлагын орчин бий болгох гэх мэтчилэн олон давуу талуудыг бий болгох сайн талуудтай.

- Үйлдвэрлэлийн дадлагад сургуулиас дадлага удирдах мэргэжилийн багш томилж явуулах.

1.Дадлага удирдсан багш наряданд тохирсон ХАБЭА-н зааварчилгаа өгдөг байх

2.Үйлдвэрийн газар АА.Нэгжүүд оюутнуудыг зөвхөн цэвэрлэгээ үйлчилгээний ажил хийлгэдэг мэргэжилийн ажилд томилдоггүй сул талтай учир дадлага удирдсан багш мэргэжилийн ажилд томилуулах түүнд таарсан ажлын наряд өгөх, аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөх зэрэг давуу талтай.

3.Мөн оюутнуудын хоол унаа,чөлөө зөвшөөрөл аюулгүй байдлыг багш өөрөө газар дээр нь шийдэх давуу талтай.